



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/266

Улаанбаатар хот

Захирамжийн хавсралтыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/1494 дүгээр захирамжийн хавсралтаар баталсан “Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд Налайх дүүрэгт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалтын тасаг (Б.Гантулга)-т, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Энхжин)-т, “1, 2” дахь заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн “Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (С.Цэдэнсодном)-т, “3” дахь заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн газар” (Г.Баярсайхан)-т, “4, 5” дахь заалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110201323

Нийслэлийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 25-ны өдрийн
А/26.6 дугаар захирамжийн
хавсралт



НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР
2024 ОНД НАЛАЙХ ДҮҮРЭГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төг)

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
1	Тохижилтын ажилд шаардлагатай материал худалдан авах (НД)	2024	2024	400.0	400.0
2	Налайх дүүргийн "Онцгой байдлын газар"-т шаардлагатай тоног төхөөрөмж (НД)	2024	2024	20.0	20.0
3	Явган хүний зам, дугуйн замын тохижилтын ажил (НД, 1, 5 дугаар хороо)	2024	2024	290.0	290.0
4	Налайх дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвд шаардлагатай автомашин худалдан авах (НД, 4, 6 дугаар хороо)	2024	2024	40.0	40.0
5	Иргэдийн оролцоотойгоор агаар хөрсний бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд алимны 3 настай 1000 ширхэг суулгацыг худалдан авч Налайх дүүргийн өрхүүдэд хүлээлгэн өгч, тариалах (НД, 1 дүгээр хороо)	2024	2024	50.0	50.0
Дүн				800.0	800.0